



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

ТҮҮХ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

ТҮҮХ

АНХНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Суралцагчийн үнэлгээ.....	2
---------------------------	---

СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Нэг. Түүхийн хичээлийн үнэлгээний шалгуур	5
Хоёр. Үнэлгээний шалгуурыг ашиглан нэгжийн үр дүнг илрүүлэх үнэлгээний даалгавар.....	11
2.1 Суурь боловсрол.....	12
2.2 Бүрэн дунд боловсрол	21
Гурав. Үнэлгээний даалгаврын гүйцэтгэлийн шинжилгээ	25

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариултыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.




Нэг. Түүхийн хичээлийн үнэлгээний шалгуур

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам¹д зааснаар “Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна. “Шалгуурт суурилсан үнэлгээ” нь сурагчийн амжилтын түвшний хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ. Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж, батална.” гэжээ.

Энэхүү журмыг хэрэгжүүлэх үүднээс суурь, бүрэн дунд боловсролын түүхийн хичээл, сургалтын үнэлгээний шалгуурыг боловсруулсан бөгөөд ингэхдээ дараах үндсэн шаардлагыг баримтлахыг хичээлээ. Үүнд:

- Багш, сурагч зэрэг хэрэглэхэд ойлгомжтой байх;
- Түүхийн сургалтын хөтөлбөрийг судалсны үр дүнд сурагчдын эзэмшвэл зохих түүхийг шинжлэн судлах арга барил, түүхийн он тооллыг тооцоолох, газар зүйн зурагтай ажиллах, түүхийн асуулт зохиох, эх сурвалж ашиглах... гэх мэт чадварыг илрүүлэхэд ашиглах боломжтой байх;

Зураг 1. Үнэлгээний шалгуур боловсруулсан үйл явц



¹ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/425 дугаар тушаалын хавсралт

Үнэлгээний шалгуурыг боловсруулахын тулд суурь, бүрэн дунд боловсролын “Түүхийн сургалтын хөтөлбөр”-ийн суралцахуйн зорилтуудыг үнэлгээний нэгжид багцлаад, багцалсан нэгжийн хүрээнд тухайн анги бүрийн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлснээр сурагчийн эзэмшсэн байх үр дүнг (Суралцахуйн үр дүн) тодорхойллоо. Үүний дараа суралцахуйн үр дүн (СҮД) тус бүрийг эзэмшсэн эсэхийг илрүүлэх шалгуур боловсруулаад тухайн шалгуур бүрийн гүйцэтгэлийн түвшний рубрукээр харуулсан болно. Энд бүрэн дунд боловсролын X-XII ангийн сонгон судлах хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг авч үзээгүй болно.

Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур (тоогоор)

	Анги					
	ҮI	ҮII	ҮIII	IX	X	XI
Үнэлгээний нэгж	3	5	5	6	4	4
Суралцахуйн үр дүн	9	10	12	11	7	6
СҮД-ийн шалгуур	18	22	22	20	14	13

- ✓ Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтуудыг үнэлгээний нэгжид багцалсан. Тухайлбал,
 - Түүхийн үечлэлийн дагуу, түүхийн үйл явдлаар болон бүс нутгаар нь багцалсан.
 - Түүхийн шинжлэх судлах арга барил болон Монголын түүхийн бахархал, үнэт зүйлсийг бие даасан үнэлгээний нэгжид багцалсан зэрэг болно.

Үнэлгээний нэгжийг суралцахуйн үр дүнг илрүүлэх шалгуур боловсруулахад зориулсан бөгөөд зарим үнэлгээний нэгж нь нэгж хичээлийн сэдэвтэй давхцаж болох боловч зарим нэгж давхцахгүй болохыг багш нар анхаарах хэрэгтэй. Учир нь үнэлгээний нэгжийг тухайн багцалсан суралцахуйн зорилтыг хэрэгжүүлснээр сурагчийн хүрсэн байх үр дүнг хэмжихэд зориулсан гэдгийг дахин тэмдэглэж байна. Тухайлбал,

- Суурь боловсролын VII ангид судлах IY-XY зууны Монгол улсын түүхэнд холбогдох суралцахуйн зорилтуудыг үнэлгээний 2 нэгж болгосон. Үүнд:
 - “Монголын нийгэм, соёл” гэсэн 2 дахь нэгжийн хүрээнд сурагч а) YI-XY зууны Монгол улсууд болон Их Монгол улс, Монголын эзэнт гүрний үеийн төр, нийгэм, соёл цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөн хөгжсөнийг холбогдох эх сурвалжид тулгуурлан тодорхойлно. б) Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний улсуудыг монголчуудын байгуулсан улс болохыг эх сурвалжид тулгуурлан тодорхойлно.” гэсэн суралцахуйн үр дүнг тодорхойлж тус бүрд нь шалгуурыг тогтоосон.
 - Харин Чингис хааны Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, түүхэн уламжлал, үнэт зүйлс, түүнийг өвлөх, бахархатай холбоотой суралцахуйн үр дүнг 5 дахь үнэлгээний нэгжид тодорхойлсон.
 - Бүрэн дунд боловсролын XI ангид судлах XVII-XX зууны эхэн үеийн Монголын түүхэнд холбогдох 11.2а., 11.2б., 11.3а., 11.3б., 11.3в., суралцахуйн зорилтыг багцлан “Түүхэн гол үйл явдал ач холбогдол, сургамж: 1636-1911 он” үнэлгээний нэгж болгон 2 суралцахуйн үр дүн, үр дүн тус бүрд 2 шалгуурыг тогтоосон болно.

Хүснэгт 2. XI ангийн “Түүхэн гол үйл явдал ач холбогдол, сургамж: 1636-1911 он” үнэлгээний нэгжийн СҮД, түүний шалгуур

Суралцахуйн үр дүн	СҮД-ийн түүний шалгуур
Монголчууд тусгаар байдлаа алдсан шалтгаан, үр дагавар, сургамжийг тодорхойлно.	Тусгаар байдлаа алдсан үйл явдлын он цагийн бичгийг хийж анхдагч болон хоёрдогч эх сурвалжаар үндэслэлээ баталж тайлбарладаг.
	Тусгаар байдлаа алдсан шалтгаан, үр дагавар, сургамжийг тодорхойлдог.

Монголчууд тусгаар тогтнолын төлөөх тэмцэл хөдөлгөөний үйл явцын үр дүнг тодорхойлно, дүгнэнэ.	Тэмцэл, хөдөлгөөний үйл явц, үр дүнг тодорхойлдог.
	Манж Чин гүрний Монголыг захирсан бодлого, шалтгаан, үр дагаврыг дүгнэдэг.

Эх сурвалж: БҮТ-өөс боловсруулсан “Түүхийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-аас авав.

- ✓ Үнэлгээний нэгж тус бүрийн хүрээнд СҮД-г тодорхойлж, уг СҮД-г илрүүлэх шалгуурыг боловсруулсан. Шалгуурыг:

- Түүхэн үзэгдэл үйл явдлын шалтгаан, үйл явц, үр дагавар, холбоо хамаарал, нөлөөлөл, өөрчлөлтийг илрүүлж тайлбарлах, тодорхойлох;
- Түүхэн үйл явдлыг орон зай, цаг хугацааны хамааралд нь түүхийн асуултын дагуу танилцуулах, жишээ гаргах, тайлбарлах, тодорхойлох, түүхэн тайлбар хийх;
- Эх сурвалж, баримт мэдээллийг ашиглан өөрийн үндэслэл, тайлбарыг батлах, нотлох гэх мэтээр тогтоосон.

Зураг 2. Үнэлгээний нэгж болон СҮД, түүний шалгуурын жишээ

ХОЁРДУГААР ХЭСЭГ. СУУРЬ БОЛОВСРОЛ

2.1. VI АНГИЙН ХИЧЭЭЛ СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

2.1.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН (СҮД) БА ШАЛГУУР

№	Суралцахуйн зорилт код	Нэгж	Суралцахуйн үр дүн (СҮД)	СҮД-ийн шалгуур
1.	6.1а. Түүхийн асуулт асуух, зохиох 6.1б. Түүхийн он тоолол, түүхэн газар зүйн зургийн талаар мэдэх, хэрэглэх 6.1в. Түүхийн эх сурвалжийг нэрлэх, ангилах, эх сурвалжтай ажиллах зарим аргыг хэрэглэх	Түүхийг судалж сурцагаа	Өнгөрсөн үед болсон түүхэн үйл явдлын агуулга бүхий асуулт зохионо, асууна.	Түүхийн асуулт зохиодог, асуудаг
			Түүхийн үйл явдал нь өнгөрсөн үед, тодорхой цаг хугацаа, газар нутаг дээр болдгийг тайлбарлана.	Түүхийн асуултын утгыг ойлгож хариулдаг.
			Түүхийн эх сурвалжуудыг ашиглан өнгөрсөн үед болсон түүхийн үйл явдлыг мэдэж болдгийг жишээгээр тайлбарлана.	Он тооллын энгийн бодлого бодох замаар тухайн түүхэн үйл НТ болон НТӨ аль онд (хэзээ) болсныг тооцоолдог, он тооллын шугам дээр он цагийг тэмдэглэдэг.
				Монгол Улсын болон дэлхийн газар зүйн зураг дээр тухайн түүхэн үйл явдал болсон газар орныг заадаг.
				Түүхийн эх сурвалжийн ангиллыг бүдүүвч зураглалаар харуулж тайлбарладаг.
				Тухайн түүхэн үйл явдлын талаарх мэдээллийг түүхийн ямар эх сурвалж ашиглан боловсруулсныг жишээ баримттайгаар тайлбарладаг.

Эх сурвалж: БҮТ-өөс боловсруулсан “Түүхийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-аас авав.

СҮД-ийн шалгуурын хэрэглээ, ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлох боломжтой байна. Үүнд:

- Үндэсний болон орон нутаг, сургуулийн түвшинд түүхийн сургалтын хөтөлбөрт нийцсэн “Даалгаврын нээлттэй сан” бүрдүүлэхдээ даалгаварт тавигдах шалгуур болгон ашиглах;
- Багш болон сурагч, бусад хэрэглэгчид түүхийн сургалтын хөтөлбөрийг судалснаар хүрэх суралцахуйн үр дүнгийн талаар нэгдсэн ойлголттой байх;
- Хөндлөнгийн болон өөрийн үнэлгээ хийх талууд нэгдсэн шалгуурыг баримтлах;
- ✓ Эцэст нь СҮД-ийн шалгуурын дагуу сурагчийн гүйцэтгэлийг I-IV түвшнээр илрүүлэхэд ашиглах үзүүлэлтийг гаргалаа. Энэхүү үзүүлэлтийг СҮД-ийн шалгуурын дагуу боловсруулсан даалгаврыг сурагчид ямар түвшинд гүйцэтгэж буйг илрүүлэхэд ашиглана. Ингэснээр сурагчдыг оношилж, тэдэнд дэмжлэг үзүүлэх, суралцахуйд нь туслах арга замыг илүү тодорхой болгох ач холбогдолтой юм.

Зураг 3. СҮД-ийн шалгуур болон гүйцэтгэлийн түвшний үзүүлэлтийн жишээ

Гүйцэтгэлийн түвшин

№	СҮД-ийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
1.	Түүхийн асуулт зохиодог, асуудаг	– Хэзээ, хаана, хэн, юу, яаж зэрэг асуух үгсийг ашиглан түүхийн холбогдолтой хураангуй асуулт зохиодог.	– Хэзээ, хаана, ямар, хэн, юу зэрэг асуух үгсийг ашиглан түүхийн холбогдолтой хураангуй асуулт зохиодог. – Бусдаас түүхийн холбогдолтой асуулт асуудаг.	– Хэзээ, хаана, яагаад, ямар, хэн, юу, яаж зэрэг асуух үгсээс заримыг нь ашиглан түүхийн холбогдолтой дэлгэрэнгүй асуултыг зохиодог. – Зохиосон асуултаа бусдаас ойлгомжтой асуудаг.	– Хэзээ, хаана, яагаад, ямар, хэн, юу, яаж зэрэг асуух үгсийг ашиглан түүхийн холбогдолтой дэлгэрэнгүй асуултыг зөв зохиодог. – Зохиосон асуултаа бусдаас тодорхой, ойлгомжтой асуудаг.
2.	Түүхийн асуултын утгыг ойлгож хариулдаг.	– Түүхийн асуултад хариулахыг оролддог.	– Түүхийн асуултад хариулдаг.	– Түүхийн асуултад ерөнхийд нь хариулдаг.	– Түүхийн асуултад бүрэн, оновчтой хариулдаг.

Эх сурвалж. БҮТ-өөс боловсруулсан “Түүхийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-аас авав.

Багш нар СҮД-ийн шалгуур болон шалгуурын гүйцэтгэлийн түвшний үзүүлэлт хоорондын холбоо, танин мэдэхүйн түвшинг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, СҮД-ийн шалгуур нь “Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний төр нийгмийн (төрийн, засаг захиргааны зохион байгуулалт) зохион байгуулалтыг тайлбарладаг.” гэсэн бол гүйцэтгэлийн бүх түвшинд “тайлбар хийх” үзүүлэлт байх ёстой. Харин СҮД-ээр сурагч түүхэн үйл явдал, тухайн нөхцөл байдал зэргийг “тайлбарладаг” болсон байх ба гүйцэтгэлийн үзүүлэлтийг “нэрлэдэг, жагсаадаг” гэсэн бол энэ нь СҮД-ийн шалгуур болон гүйцэтгэлийн үзүүлэлтийн түвшин зөрчилдсөн байна. Өөрөөр хэлбэл, СҮД нь танин мэдэхүйн аль түвшинд тодорхойлогдсон байна, гүйцэтгэлийн үзүүлэлт нь тухайн түвшинд байхаар боловсруулсныг анхаарна уу.

СҮД-ийн шалгуур болон гүйцэтгэлийн түвшний үзүүлэлт, боловсруулсан даалгаврын уялдаа холбоог дараах жишиг даалгавруудаар харуулахыг хичээлээ.

СҮД-ийн шалгуурын дагуу даалгавар боловсруулах, сурагчдын гүйцэтгэлийг үнэлэхдээ тухайн шалгуур болон гүйцэтгэлийн үзүүлэлттэй холбоотой нэр томъёог нэгэн утгаар хэрэглэх нь чухал. Тухайлбал, түүхийн хичээлээр сурагчдын хүрсэн байх нэг гол үр дүн бол түүхэн үйл явдлыг тайлбарладаг (explanation; explain) болсон байх явдал юм. Мөн ахлах ангийн сурагчдын хувьд түүхийн тайлбар (interpretation; interpret) хийж чаддаг болсон байна. Энэхүү хоёр тайлбар нь танин мэдэхүйн түвшин, сурагчдын гүйцэтгэж буй суралцахуйн үйлийн хувьд ихээхэн ялгаатай. Түүхэн үйл явдлыг тайлбарлах (explanation; explain) нь ойлголт, учир шалтгааны талаарх мэдлэгээ хэрэглэж, баримт, жишээтэйгээр бусдад мэдээлэх явдал бөгөөд энэ нь ихэнхдээ сурагчдын ойлгох, хэрэглэх заримдаа задлан шинжлэх түвшний мэдлэг, чадвар эзэмшсэнийг илтгэдэг. Харин түүхийн тайлбар (interpretation; interpret) хийх нь илүү дээд түвшний задлан шинжлэх, бүтээх үйлийг сурагчдаас шаарддаг.

Үнэлгээнд оролцогч талууд шалгуур болон гүйцэтгэлийн үзүүлэлтийг нэгэн утгаар ойлгосноор даалгаврыг боловсруулах, сурагчдыг бодитой үнэлэх боломжтой болно. Мөн даалгаврын гүйцэтгэлд шинжилгээ хийж, сурагчдад дэмжлэг үзүүлэх, хичээлийн төлөвлөлт, хэрэглэгдэхүүн зэргийг сайжруулахад хэрэгтэй.

Нэр томъёоны тайлбарыг хийхдээ сургалтын хөтөлбөр болон монгол хэлний тайлбар толь бичиг мөн зарим улс орны түүх, нийгмийн ухааны сургалтын үнэлгээнд хэрэглэдэг гүйцэтгэлийн үзүүлэлт² зэрэг эх сурвалжийг ашиглалаа.

² www.australiancurriculum.edu.au/f-10-curriculum/humanities-and-social-sciences/hass/glossary

Хүснэгт 3. Үнэлгээний зарим нэр томъёоны тайлбар

Нэр томъёо	Тайлбар
Оновчтой	Нарийвчилсан, тодорхой, стандарт, дүрэм, журам болон бусад баримтын дагуу, бүх талаар зөв байх
Шинжилгээ (анализ) хийх	Утга учир, уялдаа холбоог олж тогтоох, зүй тогтол, адил болон ялгаатай талыг илрүүлэхийн тулд бүх талыг нарийвчлан харгалзаж үзэх
Хүчин зүйлс	Тухайн түүхэн болон нийгмийн үйл явдалд гол нөлөө үзүүлсэн, улс орны дотоод болон гадаад улс, дэлхий дахинд болсон, өрнөсөн үйл явдал.
Учир шалтгаан, үр дагавар	Түүхчид цаг хугацааны туршид, богино болон урт хугацааны үйл явдлын хэлхээ, гинжин өрнөлийг тогтооход хэрэглэдэг.
Өөрчлөлт болон үл тасрах/үргэлжилсэн байдал	Түүхийн өөрчлөлт болон үргэлжилсэн байдал нь цаг хугацааны явцад шинэчлэгдэж, өөрчлөгдсөн болон уламжлагдан ирсэн зан заншил, зан үйл, үзэл санаа зэрэг байдаг. Тухайлбал, уламжлал, зан заншил нь өнгөрсөн үед, тодорхой хүчин зүйлсийн нөлөөгөөр бий болсон боловч тодорхой цаг хугацааны туршид хэвээр хадгалагдан үлдсэн байдаг.
Өөрчлөлт	Өнгөрсөн үед бий болсон, бүрэлдэн тогтсон боловч түүхийн цаг хугацааны явцад сайжирсан, хувьсан болон хувирган өөрчилсөн байдал
Цаг тоолол (түүхэн цаг хугацаа)	Цаг хугацааг судлах: Түүхийн үүднээс, цаг тоолол нь үйл явдал, өрнөлийг цаг хугацааны дэс дарааллаар нь харах, ойлгох явдал юм.
Харьцуулалт	Аливаа зүйлс хоорондоо адил төстэй, эсвэл ялгаатай байгааг багцаалах, хэмжих, тэмдэглэх
Өргөн хүрээтэй	Холбогдох бүх хүчин зүйлсийг багтаасан, нарийвчилсан, ул суурьтай
Тодорхойлох; тайлбарлах	Түүхийн үйл явдал, тэдгээрийн шинж чанарыг дүрслэх, илэрхийлэх
Нарийвчлал, нарийвчилсан	Тухайн үйл явдалд холбогдох зүйлийг болон цаг хугацаа зэргийг оролцуулах
Боловсруулах	Дэлгэрүүлж, өргөжүүлж, нарийвчлах үйл явц.
Хөгжил	Хүмүүсийн сайн сайхны тулд эдийн засаг, нийгэм, улс төрийн хүрээнд дэвшилтэт өөрчлөлт хийх, гарах (өөрчлөлтийг харна уу).
Ялган таних	Бүх талыг нь харгалзсан сонголт хийхийн тулд сайтар тунгаан бодсон байх
Зураглах	Бүдүүвчлэх, дүрслэх, бичих зэрэг арга хэлбэрээр тухайн үйл явдлыг найруулах, бүтээх
Баримт нотолгоо	Түүхэн үйл явдлыг сэргээн бүтээх үүднээс түүхэн эх сурвалжаас илрүүлж болох зүйлс (эх сурвалж, анхдагч болон хоёрдогч эх сурвалжийн харна уу).
Тайлбарлах (explanation; explain)	Ойлголт, учир шалтгааны талаарх мэдлэгээ хэрэглэж, баримт жишээтэйгээр мэдээлэх
Хэсэгчилсэн, хагас, дутуу	Уялдаа холбоотой бус, бүрэн бус, нөхцөл байдалд тааруулж хэрэглээгүй.
Шинжлэн судлах (түүхэн)	Өнгөрсөн үед болсон үйл явдлыг ойлгох зорилгоор хийж буй судлах үйл явц. Энэ нь асуулт асуухаас эхлэн эх сурвалжийг олж илрүүлэн, анализ хийх, баримт нотолгоо, мэдээлэлд суурилан өнгөрсөн үеийн талаар тайлбар боловсруулах хүртэлх цогц үйл ажиллагаа
Түүхэн үг хэллэг, ухагдахуун	Түүх судлалд хэрэглэдэг өнгөрсөн үеийн хийсвэр шинж чанар, мөн чанарыг илэрхийлсэн үг, хэллэг (колоницлол, хувьсгал, империализм, ардчилал), эсвэл илүү тодорхой шинж чанарыг илэрхийлсэн үг, хэллэг (пирамид, гладиатор, сүм хийд, хадан сууц гэх мэт).
Тогтоох, олж тогтоох	Хэн, юу, хэзээ гэдгийг олж тогтоох

Нэр томьёо	Тайлбар
Түүхийн тайлбар хийх (interpretation; interpret)	Өнгөрсөн үеийг тайлбарлах, жишээлбэл тодорхой хүн, үйл явдал, өрнөлийг холбоо хамаарал, учир шалтгаанд нь, хэд хэдэн эх сурвалжийг шинжлэх замаар өөрийн дүгнэлт, байр суурийг оролцуулан тайлбарлах. Түүхийн зарим үйл явдлыг хэд хэдэн янзаар тайлбарладаг. Энэ нь түүхчид өөр, өөр эх сурвалж хэрэглэсэн, өөр, өөр асуултууд асуусан, тухайн үйл явдалд ялгаатай үзэл бодлоор хандсантай холбоотой.
Сайжруулах	Чанарыг сайжруулах, эсвэл илүү тодорхой болгох үүднээс өөрчлөлт хийх, хувиргах, зохилдуулах
Байр суурь	Түүхийн үүднээс авч үзвэл байр суурь гэдэг нь үйлдэл, үйлд баримтлах итгэл үнэмшил, санаа бодлын цогц, эсхүл ертөнцийг үзэх үзэл юм. Байр суурь нь хүн, эсхүл хэсэг бүлгийн нас, хүйс, туршлага, шашин соёл, угсаа гарал, итгэл үнэмшил болон оюуны чадавх зэргээс шалтгаалах бөгөөд тэдний ертөнцийг үзэх үзэл, үзэл бодол, үнэ цэн, үйлдлийг тодорхойлж байдаг. Байр суурийн хоёр хэлбэр байна. Үүнд: - Хүмүүсийн үзэл бодол, байр суурь - Өнгөрсөн болон одоо үеийн үйл явдал, үзэгдлийг харах байр суурь
Илтгэх	Тодорхой сэдвээр мэдээлэх, тодорхой сэдвийг хөндөх, ялангуяа дүрс, зураг, цахим өгөгдөл, үзүүлэн гэх мэтээр баяжуулсан байх.
Анхдагч эх сурвалж	Түүхийн үүднээс анхдагч эх сурвалж гэдэг нь тухайн судалж буй цаг хугацаанд бүтээгдсэн, бичигдсэн эд зүйл, баримт бичиг юм. Жишээлбэл, тодорхой үйл явдал болж байх үед, эсвэл дөнгөж дараах нь бүтээгдсэн, бичигдсэн. Үүнд: хууль, гэрээ, хэлцэл гэх мэт албан ёсны бичиг баримтууд, өдрийн тэмдэглэл, захидал, гэрэл зураг, видео бичлэг, хувь хүний бичиг баримт, эд өлгийн зүйлс, амаар ярьсан түүх зэрэг орно. Өнгөрсөн цаг үетэй холбогдолтой асуултад хариулахын (асуудлыг шийдэх) тулд эдгээр анхдагч эх сурвалжуудад шинжилгээ хийдэг (эх сурвалж, хоёрдогч эх сурвалжийг харна уу).
Үйл явц	Тодорхой арга аргачлалын дагуу бэлтгэх, сайжруулах, хоорондоо харилцан уялдаатай, эхэлснээс дуусах хүртэлх алхмаар харуулах
Холбогдолтой, нийцтэй	Логик уялдаа холбоо хамааралтай.
Хоёрдогч эх сурвалж	Түүхийн үүднээс хоёрдогч эх сурвалж гэдэг нь тухайн судалж буй цаг хугацаанаас хойш бүтээгдсэн, ихэнх тохиолдолд анхдагч эх сурвалжийг ашиглаж, эш татан бүтээсэн, тодорхой байр сууринаас тайлбарласан эх сурвалжийг хэлнэ. Жишээлбэл, түүхчдийн бичсэн бүтээлүүд, толь бичиг, баримтат кино, түүхэн сурах бичиг, вэб хуудсууд (эх сурвалж, анхдагч эх сурвалжийг харна уу).
Дараалалд оруулах	Тодорхой дараалалд оруулах. Түүхийн үүднээс дараалалд оруулах гэдэг нь он цагийн дараалалд оруулах багтана.
Ач холбогдол	Том зургаар харвал, нийгэм, эсвэл хүмүүсийн хувьд чухал үр дагавар авчирсан, тодорхой хугацаанд үргэлжилсэн, одоо үетэй холбоотой өнгөрсөн үеийн үйл явдал, түүхэн үеийн талаарх байр суурь болон үзэл санаа
Эх сурвалж	Өнгөрсөн үеийг судлахад хэрэглэгдэх бичигдсэн буюу бичигдээгүй аливаа хэрэглэгдэхүүн Жишээлбэл, зоос мөнгө, гэрэл зураг, захидал, булшны чулуу, барилга, сийрүүлсэн хуулбар, тодорхой лавлагаанд үнэ цэнтэй байх аваас тухайн эх сурвалж баримт нотолгоо болж хувирна. (анхдагч эх сурвалж, хоёрдогч эх сурвалжийг харна уу).
Эх/текст	Эхийн тогтсон хэлбэр, хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь бидэнд янз бүрийн зорилгоор, янз бүрийн харилцагчидтай үр өгөөжтэйгөөр холбоо харилцаа тогтоож, бусадтай харилцахад тусалдаг. Эх нь амаар, бичгээр, хосолсон, хэвлэмэл эсвэл цахим хэлбэрээр байж болно. Хосолсон эх нь хэлийг харилцаа холбооны бусад системтэй (хэвлэмэл, харагдах дүрс, дуу эгшиг, хэлсэн үг, хальс эсвэл компьютер дээр буулгасан медиа) холбосон байдлыг хэлнэ.

Хоёр. Үнэлгээний шалгуурыг ашиглан нэгжийн үр дүнг илрүүлэх үнэлгээний даалгавар

Багш нар та бүхэн үнэлгээний нэгжид харгалзах СҮД, түүний шалгуур болон шалгуур тус бүрийн хувьд тодорхойлсон гүйцэтгэлийн түвшний үзүүлэлтийг ашиглан хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн нэгжийн, явцын, үр дүнгийн үнэлгээнд ашиглах даалгаврыг боловсруулах боломжтой. Зөвлөмжийн энэ хэсэгт нэгдүгээр хэсгээр танилцуулсан СҮД-ийн шалгуур, гүйцэтгэлийн түвшний үзүүлэлтийн дагуу суурь (VII анги) болон бүрэн дунд (XI анги) боловсролын түвшин бүрд нэг ангийг сонгон боловсруулсан жишиг даалгаврыг танилцуулж байна.

Сурагчдын гүйцэтгэлийн түвшний үзүүлэлтийг даалгавар бүрээр тодорхойлсон бөгөөд үүнийг СҮД, түүний гүйцэтгэлийн түвшин, мөн нэр томьёоны тайлбараас тодруулан харж хэрэглэхийг зөвлөж байна. Тухайлбал, VII ангийн Монголын нийгэм, соёл үнэлгээний нэгжид СҮД-ийн шалгуурыг “Их Юань, Алтан Ордон, Цагадайн болон Ил Хаант Улс нь Монголчуудын байгуулсан улс болохыг түүхэн эх сурвалж ашиглан тодорхойлдог” гэж тодорхойлно. Иймээс сурагч гүйцэтгэлийн аль ч түвшинд эх сурвалжийг шинжлэн ялгаатай, төсөөтэй шинж чанарыг илрүүлсэн үр дүнгээ хэрэглэн эдгээр улс нь монголчуудын байгуулсан улс болохыг дүрслэх, илэрхийлэх юм.

Сурагчид даалгаврыг “бүрэн, зөв, оновчтой” хийсэн нь гүйцэтгэлийн IY түвшний үзүүлэлтийг хангаж байгаа бөгөөд “бүрэн, зөв, оновчтой” тухайн даалгаварт өгсөн түүхэн үйл явдалд холбогдох түүхэн хүмүүс, газар нутаг, цаг хугацаа зэргийг оролцуулан нарийвчлан авч үзэж, тодорхой, эх сурвалж, баримтын дагуу бүх талаар зөв гүйцэтгэсэн байна. Харин III түвшний гүйцэтгэлийн хувьд нарийвчлан авч үзээгүй, тодорхой биш боловч ерөнхийд нь бүгдийг гүйцэтгэсэн байна. II түвшний гүйцэтгэл нь сурагч тухайн даалгаврыг хэсэгчилсэн, хагас, дутуу, алдаатай хийсэн байдлаар илэрнэ. Өөрөөр хэлбэл, сурагч тухайн даалгаврыг гүйцэтгэхдээ баримт, эх сурвалжийг ашиглаагүй ба уялдаа холбоотой бус, бүрэн бус, зарим нь алдаатай байна. I түвшний гүйцэтгэлтэй сурагчийн хувьд даалгавар тус бүрийн өгсөн түүхэн нэр томьёо, ойлголтыг оруулсан өгүүлбэр зохиох, бүдүүвч, газрын зураг дээр

алдаатай боловч ажилласан байна. Энэ нь тухайн сурагчийн идэвх зүтгэлийг харуулахын зэрэгцээ багш тухайн сурагчийг цаашид хэрхэн дэмжиж ажиллах талаарх мэдээллийг авна.

Даалгавар бүрээр СҮД-ийн шалгуурын дагуу боловсруулагдсан 4-8 ажлыг төлөвлөсөн бөгөөд сурагчид даалгавар тус бүрийн гүйцэтгэлээр СҮД-ийн шалгуурыг хангаж чадаж буй эсэхээ үнэлүүлнэ. Аль ч даалгаврын эхний ажлуудыг явцын үнэлгээнд, сүүлийн даалгаврыг эцсийн үнэлгээнд ашиглаж болох бөгөөд үүнийг сурагчдын түвшин, сургалтын цаг хугацааг харгалзан багш шийднэ.

2.1 СУУРЬ БОЛОВСРОЛ

Анги: YII
Үнэлгээний нэгж: Монголын нийгэм, соёл

Даалгавар 1.

Үнэлгээний нэгж Монголын нийгэм, соёл

Суралцахуйн үр дүн YI-XY зууны монгол улсуудын төр, нийгэм, соёл нь цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөн хөгжсөнийг холбогдох эх сурвалжид тулгуурлан тодорхойлно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний төр нийгмийн (төрийн, засаг захиргааны зохион байгуулалт) зохион байгуулалтыг тайлбарладаг.

Даалгавар нь сонгох, Газарзүйн зурагтай ажиллах, бүдүүвч хийх болон тайлбар бичих ажил бүхий 8 даалгавартай. Эдгээр даалгаврууд хоорондоо холбоотой ба сурагчид эхний 7 даалгаврыг гүйцэтгэсний үндсэн дээр Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний төр нийгмийн (төрийн, засаг захиргааны зохион байгуулалт) зохион байгуулалтыг тайлбарлаж чадаж буй эсэхийг 8 дахь даалгаврын гүйцэтгэлээр илрүүлэхээр боловсруулсан болно.

Хүснэгт 4. Даалгаврын зорилт

Даалгавар 1) 1-4, 2) 5, 3) 6	- Эх сурвалж, баримтаас мэдээлэл олж авч чадсан эсэхийг илрүүлнэ. - Засаг захиргааны аравтын тогтолцоо Хүннү улсын үеэс уламжлагдан ирснийг сэргээн санаж байгаа эсэхийг тогтооно. - Тухайн агуулгын хүрээнд тайлбар хийхдээ олж авсан мэдээллээ ашиглана.
Даалгавар 3) 7	- Засаг захиргааны тогтолцоог бүдүүвчээр харуулж чадаж буй эсэхийг илэрхийлэх ба бүдүүвчийг хийхдээ сурагч тухайн тогтолцоог тайлбарлаж байдгийг анхаарах хэрэгтэй.
Даалгавар 4) 8	- Өгсөн загвар, үгсийг ашиглан нөхөн бичих замаар тайлбар бичнэ. - Эх сурвалжийн мэдээ болон даалгаврын гүйцэтгэлээ ашиглан Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний төрийн, засаг захиргааны зохион байгуулалтын талаар тайлбарлаж буй эсэхийг илрүүлнэ.

Гүйцэтгэлийн түвшин: БҮТ-өөс боловсруулсан “Түүхийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-аас авав.

I	II	III	IV
Тухайн үеийн монголчуудын нийгмийн зохион байгуулалтыг эзэн харьяатын ёс үүссэн, алтан ураг бий болсон гэх зэрэг ойлголтыг оролцуулан тайлбарладаг.	Тухайн үеийн монголчуудын нийгмийн зохион байгуулалтыг дараах хүрээнд тайлбарладаг. Үүнд: – Тухайн үеийн монголчуудын нийгмийн байдал: эзэн харьяатын ёс үүссэн, алтан ураг бий болсон.	Тухайн үеийн монголчуудын нийгмийн зохион байгуулалтыг дараах хүрээнд түүхэн эх сурвалжийг ашиглан ерөнхийд нь тайлбарладаг. Үүнд: – Тухайн үеийн монголчуудын нийгмийн байдал: эзэн-харьяатын ёс, язгууртан гэх мэт – Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалт	Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний төр, нийгмийн зохион байгуулалт, түүний өөрчлөлтийг дараах хүрээнд түүхэн эх сурвалжийг ашиглан бүрэн тайлбарладаг. Үүнд: – Монгол улсуудын төрийн, засаг захиргааны зохион байгуулалт түүний уламжлал, өөрчлөлт – Тухайн үеийн монголчуудын нийгмийн байдал: эзэн-харьяатын ёс, алтан ураг

Мэдээлэл болон Монголын нууц товчооны хэсгийг уншаад өгсөн ажлыг гүйцэтгэнэ үү.

1206 онд Онон мөрний эхэнд ноёдын их хуралдай болж Тэмүжинд “Чингис хаан” цолыг дахин олгож Их Монгол улс байгуулагдсаныг албан ёсоор тунхагласан. Ийнхүү Умард байгалиас өмнө зүг түмэн газрын цагаан хэрэм хүртэл, зүүн зүг Хянганы нуруунаас өрнө зүг Алтайн уулс өнгөртөл уудам нутаг дэвсгэрт шинэ хүчирхэг улс мандан тогтсон.

Улсаа баруун, төв, зүүн гурван түмэнд хувааж аравтын тогтолцооны дагуу аравт, зуут, мянгат, түмт нэгжид хуваан 95 хүнийг нэр цохож мянганы ноёноор өргөмжилсөн. Тэд нийгмийн шинэ язгууртны давхаргыг бүрдүүлэх болсон.

Улсын хүн амын үндсэн хэсэг нь малчид, анчин гөрөөчин ардууд байв. Тэд харьяалагдах байдлаараа хоёр янз байдаг ба “хувь иргэн”, “харьяат иргэн” гэнэ. Мянганы ноёдод захирагдаж улсын албыг залгуулах хэсгийг “харьяат иргэн” гэнэ. Иргэд тайван цагт мал маллаж, хааны тогтоосон албыг гаргана.

Эх сурвалж: Монгол улсын түүх II боть

- “Боорчу баруун гарын Алтай дэрлэхүүний түмнийг мэдтүгэй хэмээн зарлиг болов”.
- “Мухали гоо ван зүүн гарын Харагун жидүнийг (Хянганы нуруу) дэрлэхүүний түмэн мэдтүгэй хэмээн зарлиг болов”.
- “Эдүгээ Наяа төвийн түмэн мэдтүгэй хэмээн зарлиг болов”.
- “Эртишгудас ойн иргэнд хүртэл нутаг дархлан нутаглаж ойн иргэнийг даруулан Хорчи түмэн мэдтүгэй хэмээн зарлиг болов”.

Эх сурвалж: Сурах бичиг
7 дугаар анги МНТ. УБ.,
2011. §. 205, 206, 220, 207

1) Зөв хариултыг тэмдэглэнэ үү.

- Хааны удмынхныг хэрхэн нэрлэж байсан бэ?
 - Талын язгууртан
 - Алтан ургийнхан
 - Ихэс дээдэс
 - Төрөл бус тайж
- Чингис хаан ба түүний удмынхны өмч болсон, эзэндээ зүтгэх үүрэг бүхий хүмүүсийг хэрхэн нэрлэдэг вэ?
 - Харьяат иргэн
 - Суурин иргэн
 - Хувь иргэн
 - Урт дурын хүн
- Чингис хаан 1206 онд Хүннү нараас уламжилж ирсэн аравтын зохион байгуулалтыг нэвтрүүлж, мянгатын ноёдод улс төрийн эрх олгосон. Доорх өгөгдлөөс мянгатын ноёдын улс төрийн эрхийг тодорхойлно уу.

- A. Сэцдийн зөвлөлд орж төрийн хэргийг хөтлөн явуулах, бодлого шийдвэр гаргахад шийдвэрлэх нөлөө үзүүлэх
- B. Алба гувчуур тогтоох, өртөө улаа байгуулах, харь оронтой дайтах, найрамдах асуудлаар Чингис хаанд зөвлөх
- C. Их хуралдайгаар хаан өргөмжлөх, харь оронтой найрамдах, дайтах, алба гувчуур хураах зэрэг асуудлыг шийдэхэд оролцох
- D. Их заргачтай хамтарч их засаг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих

4. Засаг захиргааны аравтын тогтолцоо Монголын аль улсын үеэс уламжлагдан ирсэн бэ?

- A. Уйгар улс
- B. Нирун улс
- C. Хүннү улс
- D. Сяньби улс

2) Газар зүйн зурагт тэмдэглэнэ үү.


5. Газар зүйн зургийг ажиглан түмэнгүүдийг хэдийн тоогоор тэмдэглэснийг тохируулна уу.



- Алтай дэрлэхүүний түмэн
- Төвийн түмэн
- Харагун жидүн дэрлэхүүний
- Ойн түмэн

3) Бүдүүвчийг гүйцээж бүтээнэ үү.

6. Их Монгол улсын хүн амын давхаргыг харуулсан дараах бүдүүвчийг гүйцээнэ үү.



7. Түмэн нь дотроо ямар нэгжид хуваагдаж байсныг бүдүүвчээр үзүүлнэ үү.

4) Тайлбарлан бичнэ үү.

8. Эх сурвалжийн мэдээ болон даалгаврын гүйцэтгэлээ ашиглан Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний төр, засаг захиргааны зохион байгуулалтын талаар тайлбар бичнэ үү. Дараах жишиг загвар болон өгсөн үгсийг ашиглаж болно.

Даалгаврын гүйцэтгэлийн түвшний илрүүлэх үзүүлэлт

Танилцуулга бичих жишиг загвар

1. Их Монгол улс зууны онд байгуулагдсан. Их Монгол улс нь улсын үеэс уламжлагдан ирсэн зохион байгуулалтыг ашиглан засаг захиргааны зохион байгуулалтыг хийсэн байдаг. Чингис хаан өөрийн шадар туслах, жанжидаар түмт, мянганыг захируулж, иргэдийг таслан өгсөн.
.....
2. Их Монгол улсын үед эзэн харьяатын ёс тогтсон. Тухайлбал, зэрэг язгууртан ноёд, зэрэг энгийн хүн амд хуваагдан –ууд нь-дад захирагдаж байжээ. Энэ талаар эх сурвалжид гэж тэмдэглэсэн байна.
.....

(Ашиглах зарим үгс: XIII зуун, хувь иргэн, харьяат иргэн, алтан ураг, түмтийн болон мянганы ноёд, эзэн харьяатын ёс ...)

Хүснэгт 5. Гүйцэтгэлийн түвшин “Түүхийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур

Шалгуур	I	II	III	IV
Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний төр нийгмийн (төрийн, засаг захиргааны зохион байгуулалт) зохион байгуулалтыг тайлбарладаг.	- 1-4 дүгээр сорилоос 2-ыг зөв тэмдэглэсэн. - Газарзүйн зурагт түмтүүдийг байрлуулах гэж оролдсон. - 6-р даалгаврын бүдүүвчийг алдаатай боловч гүйцээсэн. - 7-р даалгаварт түмтийг нэгжид хуваахыг оролдсон. - 8 дугаар даалгавар: Наад зах нь алтан ураг, ноёд, энгийн ард зэрэг үгсийг ашиглан өгүүлбэр бичсэн.	- 1-4 дүгээр сорилоос 2-ыг зөв тэмдэглэсэн. - Газарзүйн зурагт түмтүүдийг байрлуулах гэж оролдсон. - 6-р даалгаврын бүдүүвчийг алдаатай боловч гүйцээсэн. - 7-р даалгаварт түмнийг мянган, зуун, арванд хуваагддагийг алдаатай боловч бүдүүвчээр харуулахыг оролдсон. - 8 дугаар даалгавар: Жишиг загвар, өгсөн үгсээс эзэн харьяатын ёс, алтан ураг, энгийн ард иргэд зэрэг үгсийг ашиглан өгүүлбэр бичсэн.	- 1-4 дүгээр сорилыг бүрэн, эсвэл 1-ийг алдаатай тэмдэглэсэн. - Газарзүйн зурагт түмтүүдийг 2-оос доошгүйг зөв байрлуулсан. - 6-р даалгаврын бүдүүвчийг 1-2 алдаатай боловч бүрэн гүйцээсэн. - 7-р даалгаварт түмэн нь мянган, зуун, арван гэсэн засаг захиргааны нэгжид хуваагддагийг ерөнхийд нь харуулсан бүдүүвчийг зурсан. - 8 дугаар даалгавар: Жишиг загвар, өгсөн үгсийг ашиглан тайлбар бичсэн.	- 1-4 дүгээр сорилыг бүрэн, зөв тэмдэглэсэн. - Газарзүйн зурагт түмтүүдийг зөв байрлуулсан. - 6-р даалгаврын бүдүүвчийг алдаагүй, бүрэн гүйцээсэн. - 7-р даалгаварт түмэн нь мянган, зуун, арван гэсэн засаг захиргааны нэгжид хуваагддагийг бүрэн харуулсан бүдүүвчийг зурсан. - 8 дугаар даалгавар: Жишиг загвар, өгсөн үгсийг ашиглан агуулгыг дэлгэрүүлэн тайлбар бичсэн.

Оноо өгөх хүснэгтэн зөвлөмжийг ашиглан сурагчдын гүйцэтгэлийг үнэлэх боломжтой. Үүнийг ашиглахдаа багш сурагчдын гүйцэтгэл бүрийг бүхэл оноогоор үнэлэх, мөн ойролцоо утгатай үгээр хариулж буйг харгалзан хариултын төрөлд оруулж өгөх нь зүйтэй юм.

Хүснэгт 6. Онооны зөвлөмж

№	Зөв хариулт	Хариултын төрөл	Оноо
1	1	Алтан ургийнхан	1
		Бусад тохиолдолд	0
	2	Хувь иргэн	1
		Бусад тохиолдолд	0
	3	Алба гувчуур тогтоох, өртөө улаа байгуулах, харь оронтой дайтах, найрамдах асуудлаар Чингис хаанд зөвлөх	1
		Бусад тохиолдолд	0
	4	Хүннү улс	1
		Бусад тохиолдолд	0
2	5	Баруун, зүүн, төв, ойн түмэн гэж тэмдэглэсэн бол	4
		3-ыг тэмдэглэсэн бол	3
		2-ыг тэмдэглэсэн бол	2
		1-ийг тэмдэглэсэн бол	1
		Бусад тохиолдолд	0
3	6	2. Энгийн ард, В. Түмэн, мянганы ноён, заргач, төрийн бэхи, D. анчин гөрөөчин гэж бичсэн бол	3
		2-ыг хариулсан бол	2
		1-ийг хариулсан бол	1
		Бусад тохиолдолд	0
	7	Түмэн, мянган, зуун, арван	4
		3-ыг зөв эрэмбэлэн бүдүүвч хийсэн бол	3
		2-ыг зөв эрэмбэлэн бүдүүвч хийсэн бол	2
		1-ийг зөв эрэмбэлэн бүдүүвч хийсэн бол	1
		Бусад тохиолдолд	0
4	8	Жишээ нь, XIII зуун, 1206 он, Хүннү, аравтын, харьяат хэмээн бүгдийг зөв хариулсан бол	4
		3 үгийг зөв нөхсөн бол	3
		2 үгийг зөв нөхсөн бол	2
		1 үгийг зөв нөхсөн бол	1
		Бусад тохиолдолд	0

Даалгавар 2.

Үнэлгээний нэгж

Монголын нийгэм, соёл

Суралцахуйн үр дүн

Монголын эзэнт улсын бүрэлдэхүүний улсуудыг монголчуудын байгуулсан улс болохыг эх сурвалжид тулгуурлан тодорхойлно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

Их Юань, Алтан Ордон, Цагадайн болон Ил Хаант Улс нь монголчуудын байгуулсан улс болохыг түүхэн эх сурвалж ашиглан тодорхойлдог.

Даалгавар нь эх сурвалж түүнд өгсөн мэдээллийг уншиж хүснэгт нөхөх, ижил болон ялгаатай талыг тодорхойлох, асуултад хариулах, мэдээллийн гол агуулгыг тодорхойлох зэрэг ажил бүхий 6 даалгавартай. Эдгээр даалгаврууд хоорондоо холбоотой бөгөөд сурагчид эхний 5 даалгаврыг гүйцэтгэсний үндсэн дээр Их Юань, Алтан Ордон, Цагадайн болон Ил Хаант Улс нь монголчуудын байгуулсан улс болохыг тодорхойлохдоо эх сурвалжийг нотлох баримт болгон илэрхийлэх байдлаар боловсруулсан болно.

Сурагчид эдгээр улсыг монголчуудын байгуулсан улс болохыг нотлох нотолгоо нь өмнөх 5 даалгаварт агуулагдаж байгаа бөгөөд багш эхний 5 даалгаврыг оновчтой, зөв хийлгэхэд сурагчдаа тусална. Мөн эхний 5 даалгаврыг явцын үнэлгээнд, 6 дахь даалгаврыг эцсийн үнэлгээнд ашиглаж болно.

Хүснэгт 7. Даалгаврын зорилт

Даалгавар 1	- Монголын эзэнт гүрний үеийн зоос болон түүний талаарх мэдээлэлд үндэслэн хүснэгт нөхөх бөгөөд гол зорилго нь эзэнт улсын бүрэлдэхүүний аль улсад холбогдох зоос болохыг ялган, олж тогтоож чадаж буй эсэхийг илрүүлнэ.
Даалгавар 2	- 1 дүгээр даалгавар дээр хийсэн хүснэгтээ ашиглан ижил болон ялгаатай талыг тодорхойлох, ингэснээр сурагчид өөр газар нутагт хийсэн, өөр хэлээр бичигдсэн зэрэг ялгаатай боловч Монгол хаадын хийлгэсэн зоос болохыг тодорхойлно.
Даалгавар 3, 4	- 3 ба 4 дүгээр асуултад хариулснаар сурагчид Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний улсууд бусад улс оронтой дипломат харилцаа тогтоож, бие даан харилцаж байсныг ойлгосон гэдгээ харуулна. - Мөн тэдний дипломат захидлыг манай улс хүлээн авч музейд байрлуулахын ач холбогдлыг тодорхойлсон байна.
Даалгавар 5	- Мэдээллийн гол агуулгыг тодорхойлсноор Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний улсууд бусад улс оронтой улс төрийн хүрээнд эн тэнцүү харилцаж байсныг тогтоож чадаж буй эсэхээ харуулна.
Даалгавар 6	- Сурагчид өмнөх даалгаврыг гүйцэтгэх явцад мэдлэг, чадвараа нэгтгэн “Их Юань, Алтан ордон, Цагадайн болон Ил Хаант Улс бол монголчуудын байгуулсан, Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний улс мөн” гэсэн дүгнэлтийн нотлох үндэслэл бичнэ.

Хүснэгт 8. Гүйцэтгэлийн түвшин “Түүхийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур

I	II	III	IV
МЭГ-ний бүрэлдэхүүний улсууд нь монголчуудын байгуулсан улс болохыг дараах түүхийн баримт, эх сурвалжийн хүрээнд тодорхойлдог. Үүнд: – Тухайн улсын хаадын удам угсаа – Тухайн улсын хаадын солилцсон бичиг захидал, мөнгөн тэмдэгт	МЭГ-ний бүрэлдэхүүний улсууд нь монголчуудын байгуулсан улс болохыг дараах түүхийн баримт, эх сурвалжийн хүрээнд тодорхойлдог. Үүнд: – Тухайн улсын хаадын удам угсаа – Тухайн улсын хаадын солилцсон бичиг захидал, мөнгөн тэмдэгт – Тухайн нутаг дэвсгэрийг эзэлсэн түүх	МЭГ-ний бүрэлдэхүүний улсууд нь монголчуудын байгуулсан улс болохыг дараах түүхийн баримт, эх сурвалжийн хүрээнд ерөнхийд нь тодорхойлдог. Үүнд: – Тухайн улсын хаадын удам угсаа – Тухайн улсын хаадын солилцсон бичиг захидал, мөнгөн тэмдэгт – Тухайн нутаг дэвсгэрийг эзэлсэн түүх – Хил хязгаар гэх мэт	МЭГ-ний бүрэлдэхүүний улсууд нь монголчуудын байгуулсан улс болохыг дараах түүхийн баримт, эх сурвалжийн хүрээнд бүрэн тодорхойлдог. Үүнд: – Тухайн улсын хаадын удам угсаа – Тухайн улсын хаадын солилцсон бичиг захидал, мөнгөн тэмдэгт – Тухайн нутаг дэвсгэрийг эзэлсэн түүх – Хил хязгаар гэх мэт

1. Дараах эх сурвалж, түүнд холбогдох мэдээллийг уншиж, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

1.		1301 онд Тбилист цутгасан уг зоосны нүүрэн талд монгол бичгээр “Тэнгэрийн хүчин дор Газаны дэлдэгүүлсэн”, арабаар голд нь “Газан Махмуд” доод хэсэгт дөрвөлжин бичгээр “Газан Махмуд” Хятадаар товчлон бичсэн. Нөгөө талд нь Коран судрын үг “Калима” ба “Тбилист цутгав” гэж арабаар бичжээ.
2.		1320 онд Бухар хотод цутгасан. Зоосны нүүрэн талд арабаар “Кебек хаан”, ар талд нь “Цагаадай хааны тамга” сийлжээ Кебек хааны цутгуулсан зоосыг кебекүүд гэдэг байв. Хожим уг үг орос хэлэнд орж сунжран копейка (задгай мөнгө, зоос) гэх болжээ.
3.		Хубилай хаан 1260 онд цутгуулсан зоос. “Их төрийн гүйлгээний эрдэнэ” гэсэн Хятад бичигтэй.

Эх сурвалж: Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмж, Түүх, 2020

1. Хүснэгтийг бөглөнө үү.

Зоос	Зоос			Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний аль улс вэ?
	хийсэн (цутгасан) он	бичсэн хэл	хаадын нэр	
Зоос 1				
Зоос 2				
Зоос 3				
Зоос 4				

2. Хийсэн хүснэгтэн мэдээллээ ашиглан дөрвөн зоосны ижил болон ялгаатай талыг тодорхойлно уу.

Ижил тал	Ялгаатай тал
.....	
.....	
.....	
.....	
.....	

2. Дараах мэдээлэлтэй танилцан даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Монгол Улсаас Итали Улсад суугаа Элчин сайд Ц.Жамбалдорж Их Монгол Улс болон Ил Хаант Улсын хаад 13 дугаар зуунд Ромын Пап лам нартай харилцаж байсан түүхэн найман захидлын эх хуулбарыг ГХЯ-нд албан ёсоор хүлээлгэн өглөө.

Элчин сайд Ц.Жамбалдорж, Ром дахь ЭСЯ-ны хамт олон хоёр жилийн хугацаанд шаргуу ажилласны дүнд Ватиканы нууц архивт хадгалж буй Монголын эзэнт гүрний түүхтэй холбоотой чухал түүхэн баримт бичгүүдийн эх хуулбарыг энэ оны (2019) тавдугаар сарын 16-нд хүлээн авчээ. Үүнд, Ромын Пап IV Инноцентээс Гүюг хаанд ирүүлсэн захидал /1245.03.13/, Ромын Пап IV Урбанаас Ил хан Хүлэгүд



ирүүлсэн захидал /1263.05.23/, Ил хан Абагаас IY Клеменцэд илгээсэн захидал /1268 оны зун/, Ромын пап III Николасаас Ил хан Абагад ирүүлсэн захидал /1278.04.01/, Ил хан Абагаас Ромын католик шашны элчид олгосон аян замын баталгаа үнэмлэх бичиг /1279 он/, Ромын пап IV Николасаас Ил хан Аргунд ирүүлсэн 2 захидал /1288.04.02, 1289.07.15/, Ил хан Аргунаас Ромын пап IV Николаст илгээсэн захидал /1290 онд/-ын албан ёсны хуулбар багтаж буй юм. Эдгээр хуулбарыг Дипломат албаны музейд байрлуулах юм байна.

Эх сурвалж: news.mn

Монголын Эзэнт гүрний хаадын ордонд хааны зарлиг, өргөмжлөл, бичиг захидлын эхийг боловсруулдаг, орчуулдаг, тусгай хэмжээт цаасан дээр тогтсон хэв загвараар бичих ажлыг гүйцэтгэдэг хүмүүсийг битэгчи буюу бичээч гэх ба уг ажлыг зохион байгуулдаг байгууллагыг битэгчийн газар гэдэг байжээ.

Монгол хаадын гаргаж буй зарлиг, гадагш явуулж буй бичиг захидлууд мөн хааны алт, мөнгө, хүрэл гэрэгэ зэрэг нь бүгд нэг тогтсон загвартай байсан байна. Их хааны зарлигийн бичиг, захидал ч, бүрэлдэхүүний улсын хан нарынх ч тэр бүх зарлиг, захидал “Мөнх тэнгэрийн хүчин-дүр” гэж мөр тэтгэн эхэлдэг байв.

Их хаадаас гадагш илгээж байсан захидал бичгүүд нь илгээж байгаа этгээд болон хэнд явуулж байгаа, мөн тэдний зэрэг дэвээс хамаарч ялгавартай, тусгайлан тогтсон хэлбэр загвартай байсан нь бичиг захидлуудыг хуурамчаар үйлдэх болон нэр барих, нууцыг задруулах зэргээс сэргийлсэн хэрэг байв. Үүнийг гэрчлэх нэгэн тохиолдлыг дурдвал: Алтан ордны хан Тохтамышийн элч хэмээн Египетийн султанд зорьж очсон элчийг, Египетийн тал ханы элч хэмээн дээд зиндаанд ихэд хүндэтгэлтэй хүлээн авчээ. Элч, Султаны ордонд бараалхаж төрийн бичиг хэрэг эрхлэх газрын дарга Аль-бадр ад дин ибн Фадлаллах аль-Умари-д авч очсон захидлын бичгийг гардуулан өгчээ. Тэрбээр элчээс захидлыг гардан аваад уг захидлын цаасны хэмжээ, бичгийн тогтсон тэгээр нь мөнөөх элчийг ханы элч биш гэдгийг шууд мэдсэн байна. Учрыг тайлбарлахыг шаардахад өөрийгөө ханы элч бус харин Тохтамыш ханы Крым дэх амбан захирагч өөрийг нь илгээснийг хүлээн зөвшөөрсөн байна. Тиймээс элчийг илгээсэн эзнийх нь зиндаанд тохируулан хүлээн авалтыг өөрчлөхийг тушааж байжээ.

Эх сурвалж: <https://mongoltoli.mn> > history

3. Монголын түүхийн аль үед, ямар улсад холбогдох захидлуудыг Ватиканы нууц архиваас Монгол Улсын элчин сайдын яаманд хүлээлгэн өгсөн бэ?
4. Эдгээр захидлын эх хуулбарыг эх орондоо авчирч, музейд байрлуулах нь ямар ач холбогдолтой вэ?
5. Битэгчийн газартай холбоотой мэдээллийн гол агуулгыг тодорхойлно уу.
6. 1-5 дугаар даалгаврын гүйцэтгэлийн үндсэн дээр “Их Юань, Алтан ордон, Цагаадайн болон Ил хаант улс бол монголчуудын байгуулсан, Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улс мөн.” гэсэн дүгнэлтэд 3-оос доошгүй үндэслэл бичнэ үү.

1.
2.
3.

Хүснэгт 9. Даалгаврын шалгуурын гүйцэтгэлийн түвшний илрүүлэх үзүүлэлт

Шалгуур	I	II	III	IV
Их Юань, Алтан ордон, Цагаадайн, Ил хаант улс нь монголчуудын байгуулсан улс болохыг түүхэн эх сурвалж ашиглан тодорхойлдог.	1 дүгээр даалгавр: хүснэгтээс нэг мөр болон баганыг бөглөсөн. 2 дугаар даалгавр: ижил болон ялгаатай талыг бичихийг оролдсон. 3-4 дүгээр даалгавар: захидал аль үед холбогдох, ямар улсуудын захидал болох, музейд хадгалахын ач холбогдлыг тодорхойлохыг оролдсон. 5 дугаар даалгавар: битэгчийн газартай холбоотой мэдээллийн агуулгаас 1-ийг тодорхойлохыг оролдсон. 6 дугаар даалгавар: үндэслэл бичихийг оролдсон.	1 дүгээр даалгавр: хүснэгтээс 2-оос доошгүй мөр болон баганыг зөв бөглөсөн. 2 дугаар даалгавр: ижил болон ялгаатай талын аль нэгэнд зөв бичсэн. 3-4 дүгээр даалгавар: захидал аль үед холбогдох, ямар улсуудын захидал болох, музейд хадгалахын ач холбогдлын аль нэгийг тодорхойлсон. 5 дугаар даалгавар: битэгчийн газартай холбоотой мэдээллийн агуулгаас 1-2-ыг тодорхойлсон. 6 дугаар даалгавар: 1-2 үндэслэлийг бичсэн.	1 дүгээр даалгавр: хүснэгтийг ерөнхийд нь бөглөсөн. 2 дугаар даалгавр: ижил болон ялгаатай талыг ерөнхийд нь бичсэн. 3-4 дүгээр даалгавар: захидал аль үед холбогдох, ямар улсуудын захидал болох, музейд хадгалахын ач холбогдлыг ерөнхийд нь тодорхойлсон. 5 дугаар даалгавар: битэгчийн газартай холбоотой мэдээллийн агуулгыг ерөнхийд нь тодорхойлсон. 6 дугаар даалгавар: 2-3 үндэслэлийг ерөнхийд нь эх сурвалжаас эшлэл авч бичсэн.	1 дүгээр даалгавр: хүснэгтийг бүрэн зөв бөглөсөн. 2 дугаар даалгавр: ижил болон ялгаатай талыг зөв, бүрэн тодорхойлсон. 3-4 дүгээр даалгавар: захидал аль үед холбогдох, ямар улсуудын захидал болох, музейд хадгалахын ач холбогдлыг бүрэн тодорхойлсон. 5 дугаар даалгавар: битэгчийн газартай холбоотой мэдээллийн агуулгыг зөв тодорхойлсон. 6 дугаар даалгавар: 3 үндэслэлийг оновчтой, эх сурвалжаас эшлэл авч бичсэн.

Хүснэгт 10. Хариултын мэдээлэл

№	Зөв хариулт	Хариултын төрөл	Оноо
1	Жишээ нь, Зоос 1 1. 1301 он, 2. монгол бичиг, араб, дөрвөлжин бичиг 3. Газан хаан 4. Монголын Ил хаан улс	Зоосыг цутгасан он, бичсэн хэл, хаадын нэр, Монголын эзэнт улсын бүрэлдэхүүн улсыг нэрлэн бичсэн бол	4
		Нэг мөрөөс 3-ыг бичсэн бол	3
		Нэг мөрөөс 2-ыг бичсэн бол	2
		Нэг мөрөөс 1-ийг	1
		Бусад тохиолдолд	0

2	Ижил тал: Монгол хаад цутгуулсан, Өөрсдийн байгуулсан улсдаа гүйлгээнд орж байсан гэх мэт Ялгаатай тал: Дэлдүүлсэн газар, цаг хугацаа зөрүүтэй гэх мэт	Ижил болон ялгаатай талыг зөв бичсэн бол	2
		Ижил болон ялгаатай талын аль нэгийг зөв бичсэн бол	1
		Бусад тохиолдолд	0
3	XIII зуун, Монголын эзэнт гүрэнтэй холбоотой	XIII зуун, Монголын эзэнт гүрэнтэй холбоотой гэсэн утга санааг илэрхийлсэн бол	1
		Бусад тохиолдолд	0
4	Түүхийн дурсгалыг хойч үедээ таниулах, эх түүхээ сурталчлах гэх мэт	Түүхийн дурсгалыг хойч үедээ дурсгал болгон таниулах гэх мэт санааг илэрхийлсэн бол	1
		Бусад тохиолдолд	0
5	- Хэнд явуулж байгаа нь тодорхой - Зэрэг дэвээс хамаарч ялгаатай - Тогтсон хэв загвартай	Агуулгын зөв тодорхойлсон бол	1
		Бусад тохиолдолд	
6	1. Зоосон мөнгөн дээр Монгол нэр бичсэн 2. Монголчуудын эзэлж авсан газар нутаг 3. Монголчуудын дипломат харилцаа гэх мэт	Үндэслэлтэй 3 дүгнэлт бичсэн бол	3
		Үндэслэлтэй 2 дүгнэлт бичсэн бол	2
		Үндэслэлтэй 1 дүгнэлт бичсэн бол	1
		Бусад тохиолдолд	0

2.2 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

Жишиг даалгаврыг бүрэн дунд боловсролын XI ангийн “Монголын ардчиллын түүх” үнэлгээний нэгжийн хүрээнд боловсруулсан болно.

Даалгавар 1.

Үнэлгээний нэгж	Монголын ардчиллын түүх
Суралцахуйн үр дүн	1990 оны ардчилсан хувьсгалын түүх, амьдралын хүрээнд гарсан өөрчлөлтийг анхдагч болон хоёрдогч эх сурвалж ашиглан тодорхойлно.
Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Хувьсгал ялснаар Монгол улсад гарсан өөрчлөлтийг өмнөх үетэй харьцуулан тодорхойлдог.

Энэхүү даалгавар нь статистик баримт дээр ажиллаж, харьцуулах, ангилах, тооцоолол хийх, график байгуулах, УИХ-ын тогтоолоос өгч буй мэдээллийг тогтоох ажил бүхий 4 даалгавартай. Эдгээр даалгаврууд хоорондоо холбоотой бөгөөд сурагчид эхний 3 даалгаврыг гүйцэтгэсний үндсэн дээр ардчилсан хувьсгал ялснаар Монгол улсад гарсан өөрчлөлтийг эдийн засгийн амьдралын хүрээнд өмнөх үетэй харьцуулан тодорхойлохоор боловсруулсан болно.

Хүснэгт 11. Даалгаврын зорилт

Даалгавар 1, 2	- Сурагчид арав, арван жилээр малын тоог харуулсан статистик баримт дээр ажиллаж, харьцуулах, ангилах, тооцоолол хийх, график байгуулах чадвараа илэрхийлнэ. - Энэ даалгаврын гүйцэтгэлийг ардчилсан хувьсгал ялснаар Монгол улсад гарсан өөрчлөлтийг нийгмийн эдийн засгийн амьдралын хүрээнд өмнөх үетэй харьцуулан тодорхойлж түүхэн тайлбар бичихдээ нотлох баримт, үндэслэл болгон ашиглана.
----------------	--

Даалгавар 3	- УИХ-ын 1995 оны тогтоолоос ямар мэдээлэл өгч байгааг тогтооно. - Энэ нь тогтоолын агуулгыг ярина гэсэн үг биш бөгөөд харин тогтоолоос харахад ардчилсан хувьсгалын дараа өмч хувьчилж, 1995 он гэхэд хэдий хэмжээний өмчийг хувьчилсан байгааг харуулж байна гэх мэтээр судалж буй агуулгын хүрээнд авч үзэхийг анхаарах хэрэгтэй. - Сурагчид эхний 3 даалгаврыг гүйцэтгэснээр эдийн засагт гарсан өөрчлөлт нь өмч хувьчлал, хувийн өмчийг хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой болохыг дүгнэн гаргаж ирсэн байх бөгөөд энэ нь түүхэн тайлбар бичихэд нотолгоо болох ач холбогдолтой юм.
Даалгавар 4	- Сурагчид өмнөх 3 даалгаврын гүйцэтгэлээ ашиглан 1990 оноос хойш Монгол улсын эдийн засгийн салбарт гарсан гол өөрчлөлтийн талаар түүхэн тайлбар бичнэ. - Багш “Тайлбарлах - explanation; explain, “Тайлбар хийх - interpretation; interpret” гэдэг нь ялгаатай болохыг сурагчдад ойлгуулсан байна. (Нэр томъёоны тайлбар хэсгээс харна уу.)

Хүснэгт 12. Гүйцэтгэлийн түвшин “Түүхийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-аас авав.

I	II	III	IV
Хувьсгал ялснаар Монгол улсад гарсан өөрчлөлтийг дараах хүрээнд тодорхойлдог. Үүнд: – Улс төрийн хүрээнд гарсан өөрчлөлт – Нийгэм, эдийн засгийн хүрээнд гарсан өөрчлөлт – Оюун санааны хүрээнд гарсан өөрчлөлт	Хувьсгал ялснаар Монгол улсад гарсан өөрчлөлтийг өмнөх үетэй харьцуулан дараах хүрээнд тодорхойлдог. Үүнд: – Улс төрийн хүрээнд гарсан өөрчлөлт – Нийгэм, эдийн засгийн хүрээнд гарсан өөрчлөлт – Оюун санааны хүрээнд гарсан өөрчлөлт – Гадаад харилцаанд гарсан өөрчлөлт	Хувьсгал ялснаар Монгол улсад гарсан өөрчлөлтийг өмнөх үетэй харьцуулан дараах хүрээнд ерөнхийд нь тодорхойлдог. Үүнд: – Улс төрийн хүрээнд гарсан өөрчлөлтийг үндсэн хуулийн холбогдох заалтуудад тулгуурлан – Нийгэм, эдийн засгийн хүрээнд гарсан өөрчлөлтийг статистик тоо баримтад тулгуурлан – Оюун санааны хүрээнд гарсан өөрчлөлтийг холбогдох хууль, баримт бичигт тулгуурлан – Гадаад харилцааны бодлогод гарсан өөрчлөлтийг холбогдох хууль, баримт бичигт болон аялал жуулчлалын салбарт гарсан өөрчлөлтөөр	Хувьсгал ялснаар Монгол улсад гарсан өөрчлөлтийг өмнөх үетэй харьцуулан дараах хүрээнд бүрэн тодорхойлдог. Үүнд: – Улс төрийн хүрээнд гарсан өөрчлөлтийг үндсэн хуулийн холбогдох заалтуудад тулгуурлан – Нийгэм, эдийн засгийн хүрээнд гарсан өөрчлөлтийг статистик тоо баримтад тулгуурлан – Оюун санааны хүрээнд гарсан өөрчлөлтийг холбогдох хууль, баримт бичигт тулгуурлан – Гадаад харилцааны бодлогод гарсан өөрчлөлтийг холбогдох хууль, баримт бичиг болон аялал жуулчлалын салбарт гарсан өөрчлөлтөөр

Дараах хоёр баримтын өгөгдлийг анхааралтай ажиглаад даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Хүснэгт. Малын тоо (мянгаар)

Он	1950	1960	1970	1980	1990	2000	2010	2020
бүгд	22702.2	23000.5	22574.9	23771.4	25856.9	30227.5	42195.8	67068.4

Эх сурвалж: Статистикийн ерөнхий газрын мэдээ 2020 он



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ
ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ТУХАЙ
1995 оны 01 сарын 12-ны өдөр
Дугаар 11

Өмч хувьчлалын явц, өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай» Монгол Улсын Засгийн газрын сонсголыг *Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:*

“Өмч хувьчлалын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх талаар сүүлийн 3 жил гаруйн хугацаанд авсан арга хэмжээний үр дүнд дотоодын үйлдвэрлэлийн 50 гаруй хувь, худалдаа, үйлчилгээний газрууд үндсэндээ, мал сүргийн 90 гаруй хувь нь хувийн өмчид шилжин, Их хувьчлалын эрхийн бичгээр баталгаажих хөрөнгийн хувьчлал үндсэндээ дуусжээ.

Өмч хувьчлалын явцад нийт 1,9 сая гаруй хүнд хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгож, 17,4 тэрбум төгрөгийн үнэ бүхий хөрөнгө хувьчлагдан, 1,1 сая гаруй иргэд хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаа эзэмшигч болжээ. Янз бүрийн шалтгаанаар 113 мянган хүн хөрөнгө оруулалтын эрхийн бичиг авалгүй үлджээ.

Энэ ажлын үр дүнд 466 хувьцаат компани, 1297 бүрэн бус хариуцлагатай компани, 1907 хоршоо, 850 хувиараа эрхлэх аж ахуй бий болжээ.

Өмч хувьчлалын явцад туршлага дутагдаж, бодит бэрхшээл тохиолдсоны дээр бодлогын зарим алдаа, зохион байгуулалтын ажлын дутагдлаас шалтгаалсан гажуудал, зөрчил ч цөөнгүй гарав.

Эх сурвалж: УИХ-ын тогтоолоос, legalinfo.mn

1. Аль арван жилд мал хамгийн олон тоо толгойгоор өссөн бэ?

- A. 1950 - 1960 он
- B. 1990 - 2000 он
- C. 2000 - 2010 он
- D. 2010 - 2020 он

2. Статистик мэдээг хоёр хэсэгт хуваан аль оноос хойш малын тоо толгойг хэдэн хувиар өссөн, буурсныг тооцоолж, бүдүүвч, зураг (график)-ын аль нэгийг сонгон харуулна уу.

3. 1995 оны Улсын их хурлын тогтоол та бүхэнд ямар мэдээлэл өгч байна вэ?

САНАМЖ:

Түүхэн тайлбар гэдэг нь түүхийн үйл явдлуудыг талаар өөрийн уншсан, мэдсэн зүйлээ тайлбарлан ярих бичихээс ялгаатай. Энэ нь өнгөрсөн үйл явдлуудыг дүрслэн харуулаас эхлээд дүн шинжилгээ хийх, үнэлэх, тайлбарлах үйл явц юм. Түүхэн тайлбарыг түүхийн анхдагч [биет олдвор, тоо баримт, албан бичиг, эрх зүйн акт, захидал зэрэг] болон хоёрдогч [түүхчдийн бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нэгэн сэдэвт түүхийн ном зохиол, сурах бичиг зэрэг] түүхэн эх сурвалж дээр үндэслэн цогц байдлаар хийдэг. Ингэхдээ нотлох баримт, агуулга, үзэл бодол, эшлэлийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн үр дүнгээ харуулдаг.

4. 1-3 дугаар даалгаврын гүйцэтгэл болон анхдагч, хоёрдогч эх сурвалжийг ашиглан 1990 оноос хойш Монгол улсын эдийн засгийн салбарт гарсан гол өөрчлөлтийн талаар түүхэн тайлбар бичээрэй.

Хүснэгт 13. Даалгаврын шалгуурын гүйцэтгэлийн түвшний илрүүлэх үзүүлэлт

Шалгуур	I	II	III	IV
Хувьсгал ялснаар Монгол улсад гарсан өөрчлөлтийг өмнөх үетэй харьцуулан тодорхойлдог.	1 дүгээр даалгавар: хариулахыг оролдсон. 2 дугаар даалгавар: – статистикийг 1950-1980, 1990-2020 он гэж аль нэгийг ангилан, тооцоолол хийн график юм уу, бүдүүвчээр харуулахыг оролдсон. 3 дугаар даалгавар: “Ардчилсан хувьсгалын дараа өмч хувьчилж, 1995 он гэхэд хэдий хэмжээний өмчийг хувьчилсан байгааг харуулж байна” гэх мэтээр судалж буй агуулгын хүрээнд УИХ-ын тогтоолоос авч болох мэдээллийг тодорхойлохыг оролдсон. 4 дүгээр даалгавар: “Санамж” хэсэгт байгаа шалгуурыг хангахыг оролдсон.	1 дүгээр даалгавар: хариулсан. 2 дугаар даалгавар: – статистикийг 1950-1980, 1990-2020 он гэж аль нэгийг нь зөв ангилсан – тооцоолол хийн график юм уу, бүдүүвчээр харуулсан. 3 дугаар даалгавар: “Ардчилсан хувьсгалын дараа өмч хувьчилж, 1995 он гэхэд хэдий хэмжээний өмчийг хувьчилсан байгааг харуулж байна” гэх мэтээр судалж буй агуулгын хүрээнд УИХ-ын тогтоолоос авч болох мэдээллээс аль нэгийг тодорхойлсон. 4 дүгээр даалгавар: “Санамж” хэсэгт байгаа шалгуурыг хангасан.	1 дүгээр даалгавар: зөв хариултыг сонгосон. 2 дугаар даалгавар: – статистикийг 1950-1980, 1990-2020 он гэж ерөнхийд нь ангилсан – тооцооллыг ерөнхийд нь хийсэн – график юм уу, бүдүүвчээр ерөнхийд нь харуулсан. 3 дугаар даалгавар: “Ардчилсан хувьсгалын дараа өмч хувьчилж, 1995 он гэхэд хэдий хэмжээний өмчийг хувьчилсан байгааг харуулж байна” гэх мэтээр судалж буй агуулгын хүрээнд УИХ-ын тогтоолоос авч болох мэдээллийг ерөнхийд нь тодорхойлсон. 4 дүгээр даалгавар: “Санамж” хэсэгт байгаа шалгуурыг ерөнхийд нь хангасан.	1 дүгээр даалгавар: зөв хариултыг сонгосон. 2 дугаар даалгаварт: – статистикийг 1950-1980, 1990-2020 он гэж зөв ангилсан – тооцооллыг зөв хийсэн – график юм уу, бүдүүвчээр ойлгомжтой, зөв харуулсан 3 дугаар даалгавар: “Ардчилсан хувьсгалын дараа өмч хувьчилж, 1995 он гэхэд хэдий хэмжээний өмчийг хувьчилсан байгааг харуулж байна” гэх мэтээр судалж буй агуулгын хүрээнд УИХ-ын тогтоолоос авч болох мэдээллийг тодорхойлсон. 4 дүгээр даалгавар: “Санамж” хэсэгт байгаа шалгуурыг бүрэн хангасан.

Хүснэгт 14. Оноо өгөх зөвлөмж

№	Зөв хариулт	Хариултын төрөл	Оноо
1	2010-2020 он	2010-2020 он	1
		Бусад тохиолдолд	0
2	Бүдүүвч болон график хийсэн	Бүдүүвч болон графикийг зөв хийсэн бол	1
		Бусад тохиолдолд	0
3	Ардчилсан хувьсгалын дараа өмч хувьчилж, 1995 он гэхэд хэдий хэмжээний өмчийг хувьчилсан байгааг харуулж байна гэх мэт	Ардчилсан хувьсгалын дараа өмч хувьчилж, 1995 он гэхэд хэдий хэмжээний өмчийг хувьчилсан байгааг харуулж байна гэх мэт	1
		Бусад тохиолдолд	0
4	Өмч хувьчлалын хэрэгжүүлснээр иргэд хувийн өмчтэй болсон. 1990 оноос хойш малын тоо толгой тогтмол өссөн.	Өмч хувьчлалын хэрэгжүүлснээр иргэд хувийн өмчтэй болсон. 1990 оноос хойш малын тоо толгой тогтмол өссөн.	1
		Бусад тохиолдолд	0

Гурав. Үнэлгээний даалгаврын гүйцэтгэлийн шинжилгээ

Даалгаврт шинжилгээ хийхдээ даалгаврын гүйцэтгэлд ач холбогдол өгч гүйцэтгэлийн түвшний шалгуур үзүүлэлтийн дагуу шинжлэхийг зөвлөж байна. Даалгаврыг сайжруулах хэрэгтэй гэж үзвэл юуг нь хэрхэн өөрчилж, сайжруулах вэ гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй.

Багш даалгаврын гүйцэтгэлийг шинжлэхдээ дараах алхмыг баримтлахыг санал болгож байна. Үүнд:

- а) Юуны өмнө бүх даалгаврын ажлуудын зөв, оновчтой хариулт, хувилбарыг гаргах хэрэгтэй. Үүнд: хоёрдугаар хэсэгт танилцуулсан гүйцэтгэлийн түвшний үзүүлэлт болон оноо өгөх зөвлөмжийг ашиглах боломжтой.
- б) Багш өөрийн гаргасан зөв оновчтой хариултын хувилбараа ашиглан сурагчдын гүйцэтгэлийн түвшинг үнэлнэ.

Хүснэгт 15. Хүснэгт. Үнэлгээний даалгаврын гүйцэтгэл, шинжилгээ (загвар)

№	Сурагч	Даалгавар	Гүйцэтгэлийн түвшин				Үнэлгээний үндэслэл/тэмдэглэл (алдааны шинжилгээ)
			I	II	III	IV	
1.	Сурагч 1	1		+			- I, II түвшинд гүйцэтгэсэн даалгаврын тухайд даалгаврыг гүйцэтгэхийг оролдсон боловч тухайлан юуг, яагаад буруу, оновчгүй, алдаатай хийснийг тэмдэглэнэ.
		2			+		
		3					
		4	+				- Уг даалгаврыг зөв, оновчтой болгохын тулд сурагчид ямар дэмжлэг үзүүлж болох, ямар хэрэглэгдэхүүн ашиглаж болохыг тэмдэглэнэ.
		5		+			
							- III түвшинд гүйцэтгэсэн даалгаврын тухайд сурагч тодорхой хариулах, гүйцэтгэхтэй холбоотой анхаарах зүйлсийг тэмдэглэнэ.

Үнэлгээний даалгаврын гүйцэтгэл, шинжилгээ бүхий дээрх хуудсыг сурагч бүр дээр үнэлгээний нэгж бүрээр хөтөлж болох бөгөөд энэ нь тухайн сурагчийн ахиц амжилт, СҮД-ийн шалгуурыг хангаж буй үйл явцыг танд харуулна. Мөн үнэлгээний нотлох баримт болох ач холбогдолтой.

в) Сурагчдын гүйцэтгэлийн түвшин, үнэлгээний үндэслэл зэргийг ашиглан тухайн сурагчид үзүүлэх дэмжлэг, зөвлөгөө болон түүнд зориулсан хэрэглэгдэхүүнийг боловсруулах, бэлэн хэрэглэгдэхүүнийг ялган бэлтгэх, хэрхэн тухайн сурагчтайгаа хамтран ажиллахаа төлөвлөх нь таны дараагийн ажил юм. Энэ ажил бол сурагчийн гүйцэтгэлд шинжилгээ хийсний гол үр дүн. Тухайлбал, I, II түвшний гүйцэтгэлтэй сурагчтай ажиллах бэлтгэлээ хангах бөгөөд тэдэнтэй ганцаарчлан уулзаж, тусгайлан зориулсан зөвлөгөө, төлөвлөгөө, үнэлгээг танилцуулж, түүнтэй хамтран төлөвлөгөөгөө эцэслэх хэрэгтэй. Энэ нь сурагчийг хариуцлагажуулах, бие даан, алдаан дээрээ суралцах боломжийг олгоно.

Дээр санал болгосон алхмуудын дагуу суурь боловсролын YII ангийн Монголын нийгэм, соёл үнэлгээний нэгжийн хүрээнд боловсруулсан зарим даалгаврын гүйцэтгэлийн шинжилгээ, түүний үр дүнг хэрэглэх арга замыг жишээ болгон харуулав.

а) *Даалгаврын ажлуудын зөв, оновчтой харцулт, хувилбар*

1. Хүснэгтийг бөглөнө үү.

Зоос	Зоос			Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний аль улс вэ?
	хийсэн (цутгасан) он	бичсэн хэл	хаадын нэр	
Зоос 1	1301 он	Монгол, араб	Газан хаан	Ил хаант улс
Зоос 2	1320 он	Араб (Цагаадай хааны тамга)	Цагаадай	Цагаадайн улс
Зоос 3	1260 он	Хятад	Хубилай	Их Юань улс

2. Хийсэн хүснэгтэн мэдээллээ ашиглан дөрвөн зоосны ижил болон ялгаатай талыг тодорхойлно уу.

Ижил тал	Ялгаатай тал
- Хубилай хааны зоосноос бусад нь Монгол бичгээр бичсэн. - Бүгдийг нь Чингисийн удмын Монгол хаад цутгуулсан. - Монголын эзэнт улсын бүрэлдэхүүн улсуудад цутгасан, тэнд хэрэглэдэг. - Бүгд XIII-XIV зуунд буюу Монголын эзэнт гүрний үед цутгасан.	- Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний өөр, өөр улсад цутгасан.

3. Монголын түүхийн аль үед, ямар улсад холбогдох захидлуудыг Ватиканы нууц архиваас Монгол Улсын элчин сайдын яаманд хүлээлгэн өгсөн бэ?

Монголын түүхийн 1260-1290-ээд онд (XIII зууны дунд үеэс сүүл үед) холбогдох захидлуудыг Монгол Улсаас Итали Улсад суугаа Элчин сайдын яаманд өгсөн. Эдгээр захидлууд нь Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн болох Ил хаант улсын түүхэнд холбогдоно. Эдгээр захидлууд нь Ил хаант улсын хаад Ромын паптай харилцаж байсныг нотолж байна.

4. Эдгээр захидлын эх хуулбарыг эх орондоо авчирч, музейд байрлуулах нь ямар ач холбогдолтой вэ? Эдгээр захидлын эх хуулбарыг эх орондоо музейд тавьснаар хүн бүхэн үзэх боломжтой болно. Ингэснээр бид одоогоос 800-аад жилийн өмнө Монгол хаад дэлхийн улс оронтой харилцаж, дипломат харилцаа тогтоож байсныг мэдэж авна.

5. Битэгчийн газартай холбоотой мэдээллийн гол агуулгыг тодорхойлно уу.

Битэгчийн газар гэдэг нь хааны зарлиг, бичиг захидлын эхийг боловсруулдаг, орчуулдаг үүрэгтэй албан газар юм. Тэнд бичээчид ажилладаг байсан. Монгол хаад, түүний төлөөний ноёд Египетийн султанд хүртэл албан захиа илгээдэг байжээ. Захиаг хаан илгээсэн үү, түүний төлөөний ноён илгээсэн үү гэдгээс нь хамаарч элчид өөр өөр үйлчилгээ үзүүлдэг байна. Мөн тухайн үед хуурамч захиа байна уу, албан ёсны захиа байна уу гэдгийг таньж тодорхойлдог байжээ.

6. 1-5 дугаар даалгаврын гүйцэтгэлийн үндсэн дээр “Их Юань, Алтан ордон, Цагаадайн болон Ил хаант улс бол Монголчуудын байгуулсан, Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улс мөн.” гэсэн дүгнэлтэд 3-оос доошгүй үндэслэл бичнэ үү.

Их Юань, Алтан ордон, Цагаадайн болон Ил хаадын улс бол Монголчуудын байгуулсан, Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улс мөн. Учир нь:

1. Их Юань, Цагаадайн болон Ил хаадын улсын хаад нь Чингис хааны удмын Монгол хаад байсан.
2. Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний улсуудын хаад өөр, өөр газар нутгийг захирч байсан боловч Монгол хэлээр болон тухайн оршин суугчдын хэл дээр бичсэн зоос гаргаж, хэрэглэдэг байсан.
3. Монгол хаад Ромын пап, Египетийн хаантай албан ёсоор харилцаж байсан.

б) Сурагчдын ажлын гүйцэтгэл, алдааны шинжилгээ

Өмнөх хэсэгт танилцуулсан ажлуудын зөв, оновчтой хариулт, хувилбар болон энэхүү зөвлөмжийн 2 дугаар хэсэгт танилцуулсан “Даалгаврын шалгуурын гүйцэтгэлийн түвшинг илрүүлэх үзүүлэлт”-ийг ашиглан сурагчдын ажлыг үнэлнэ. Дараах жишээг та бүхэнд санаа өгөх үүднээс хийсвэр байдлаар, зөвхөн эхний хоёр ажил дээр авч үзсэн болохыг анхаарна уу.

Хүснэгт 16. Үнэлгээний даалгаврын гүйцэтгэл, шинжилгээ (загвар, жишээ)

№	Сурагч	Даалгавар	Гүйцэтгэлийн түвшин				Үнэлгээний үндэслэл/тэмдэглэл (алдааны шинжилгээ)	
			I	II	III	IV		
1.	Сурагч 1	1		+			- Зоос болон түүний тайлбараас шууд олж бөглөх эхний 3 үзүүлэлтийг дутуу бөглөсөн. - Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний улсын нэрийг буруу болон дутуу бичсэн. (3 улсыг нэрлэх ёстой)	- Сурвалж болон баримтаас асуултын дагуу, тодорхой мэдээллийг олж сурахад нь туслах - Энгийн хэрэглэгдэхүүн бэлтгэж ажиллуулах - Эзэнт улсын талаарх ерөнхий мэдлэг хангалтгүйгээс эх сурвалж болон тайлбарт өгсөн, дараагийн эх сурвалжаас олж болох нэрсийг тогтоож чадаагүй байж болно.

								- Эзэнт улсын талаар ТӨМ эсвэл цахим орчноос мэдээлэл хайж унших арга зааж өгөх, уншуулах, ойлгосноо ярих
		2	+					- Ижил, ялгаатай талыг бичсэн боловч тэр нь оновчгүй, тухайлбал, - Ижил тал ганцыг бичсэн - Ялгаатай талыг нь гаргаж чадаагүй
								- Эхний хүснэгтийг дутуу, буруу хийсэн тул энэ ажлын гүйцэтгэл I түвшинд байх боломжтой. Энэ нь эх сурвалж, баримтаас асуултын дагуу, тодорхой мэдээллийг олж сураагүй байна. Тиймээс: ■ Энгийн баримт мэдээллээс асуултын дагуу гол зүйлийг ялгаж, олж сурахад нь туслах ■ Олсон мэдээллүүдийн юу нь адилхан, юу нь ялгаатай байгааг асуух, тэмдэглүүлэх - Ижил, ялгаатай талыг тодорхойлох нь сурагчаас задлан шинжлэх түвшинд хийж буй үйл тул анхнаас нь сайтар чадваржуулахад анхаарна.

в) Алдааны шинжилгээний үндсэн дээр сурагчидтай ажиллах нь

Өмнөх хэсэгт алдааны шинжилгээ хийсэн 2 даалгаврыг жишээ болгон тухайн сурагчтай хэрхэн ажиллах талаар танилцуулж байна. Энэхүү 2 даалгаварт алдааны шинжилгээ хийснээр сурагч 1-д дэмжлэг үзүүлж, СҮД-ийн шалгуурыг хангадаг болоход нь туслах учиртай.

Сурагч 1-ийн алдаан дээр суралцах төлөвлөгөө (жишээ байдлаар-ерөнхий)

Хөгжүүлэх чадвар – хүрсэн байх үр дүн	Үйл ажиллагаа			Хугацаа
	багш	сурагч	хамтран	
Эх сурвалж, баримтаас асуултын дагуу, тодорхой мэдээллийг олж чаддаг болно.	- Аргачлал, удирдамж, зөвлөгөө бэлтгэнэ. - Холбогдох хэрэглэгдэхүүнийг сонгож сурагчид санал болгоно.	- Багшийн аргачлалын дагуу сонгосон эх сурвалжаас асуултын дагуу мэдээллийг ялгана.	- Сурагчийн гүйцэтгэлийг хэлэлцэнэ. Тухайлбал, сурагч ажлаа танилцуулж, багш асууна. Шаардлагатай зөвлөгөөг өгнө.	7 хоногт ...-ээс доошгүй эх сурвалж дээр ажиллана.
Ижил, ялгаатай талыг тогтоож, тодорхойлж сурна.	- Эцэг, эх, асран хамгаалагчид танилцуулж, хамтран ажиллахыг санал болгоно.			

Дээрх ерөнхий төлөвлөгөөг сурагчтай хамтран нарийвчлан боловсруулах боломжтой. Мөн сурагчдад зориулсан өөрийн үнэлгээний хуудас гаргаж, сурагчийн хийсэн өөрийн үнэлгээтэй танилцаж, түүнтэй яагаад, хэрхэн өөртөө тухайн үнэлгээг өгснийг ярилцаж болно.

Дээрх бүхэн нь явцын үнэлгээ, дэмжлэгт хамаарах бөгөөд үр дүнгийн үнэлгээ нь СҮД-ийн шалгуураар хэмжигдэхийг анхаарах хэрэгтэй.

Тэмдэглэл

[illegible]

ЕБС-ийн Түүх хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:

У.Туяа	Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор (Ph.D)
Д.Янжинжав	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Хөндлөнгийн шинжээч:

Ч.Гажиддулам	БМДИ-ийн арга зүйч, магистр
--------------	-----------------------------

Техникийн редактор:

М.Болдсайхан	Боловсролын үнэлгээний төвийн хэлтсийн дарга
Ш.Сувдмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

С.Мөнхмаа	Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр
-----------	--------------------------------------

Цаасны хэмжээ: А4

Хэвлэлийн хуудас: 4 х.х

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.eec.mn



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,
Утас/Факс: 976-11 7011- 8486
И-мэйл: info@eec.mn Вэб: www.eec.mn